



Asian Development Bank

# ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ (ХУВЬ ХҮН)



2023 он



# ГАРЧИГ

1.	ТАТВАР ТӨЛӨГЧ .....	4
2.	ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ .....	5
3.	ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД .....	6
4.	ТАТВАР ТӨЛӨГЧ-ХУВЬ ХҮНИЙ БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ .....	7
5.	ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ДУГААР, ХУВИЙН ХЭРЭГ .....	8
6.	ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ЭРХ .....	9
7.	ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ .....	11
8.	ТАТВАР ТӨЛӨГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА .....	13
8.1	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ .....	13
8.2	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ .....	15
9.	ЦАХИМ ТАТВАРЫН СИСТЕМД ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР (ХУВЬ ХҮН) БҮРТГҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР .....	19

# ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ-ХУВЬ ХҮН

## 1. ТАТВАР ТӨЛӨГЧ

- “Татвар төлөгч” гэж татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэг бүхий этгээд, эсхүл суутган төлөгчийг хэлнэ.
- Татварын харилцаанд оролцогч татвар төлөгчийг иргэн (хувь хүн), хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага (аж ахуйн нэгж) гэж ангилна.
- Тухайн татварын жилд Монгол улсад болон Монгол улсаас эх үүсвэртэй албан татвар ногдох орлого олсон, эсхүл хуульд заасны дагуу татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан татвар төлөгчөөр бүртгүүлнэ.
- Монгол улсад албан татвар ногдох зүйл өмчилж эзэмшиж, ашиглаж байгаа хувь хүний эрх бүхий бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн бүртгэлд үндэслэн татварын алба нь татвар төлөгчийн бүртгэл үүсгэж болох ба энэ талаар татвар төлөгчид түүний бүртгэлтэй хаяг, утас, цахим шуудангийн хаягаар мэдэгдэнэ.



## 2.

## ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ

- Монголын татварын алба нь дараах 3 үндсэн үүргийг хэрэгжүүлдэг.

Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах

Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

Төсвийн орлогыг бүрдүүлэх

- Татварын алба гэж татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, хот, дүүргийн татварын газар, хэлтэс, сум, тосгоны татварын тасаг, татварын улсын байцаагч, хураагчийг хэлнэ.
- Татварын ерөнхий хуульд зааснаар Монгол Улсын татвар нь албан татвар, төлбөр, хураамж /цаашид “татвар” гэх/-аас бүрдэх ба нийт 30 төрлийн татвартай байхаар хуульчилжээ.
- Үүнээс нохойны албан татвар, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр, өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын хууль батлагдаагүй ба бусад 27 төрлийн албан татвар, төлбөр, хураамжийн ногдуулалт төлөлтөд татварын алба, гаалийн байгууллага нь хяналт тавьж ажилладаг.
- Татварын алба нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд татвар төлөгчдийг бүртгэж, тэдэнд татвар ногдуулж төлөх үүрэг хариуцлагыг нь сурталчлан таниулах, тайлан хүлээн авах, татвар хураах, хяналт шалгалт хийх, маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх зэргээр үйлчилгээ үзүүлэн ажилладаг.
- Татварын хуулиар татвар төлөх, эсхүл татвар суутгах үүрэг хүлээсэн бүх хувь хүн татвар төлөгчөөр заавал бүртгүүлнэ.

Татвар төлөгчийн бүртгэлийн үйл ажиллагаа нь татвар хураалтын процесс-үйл ажиллагааны хамгийн эхний, хамгийн хариуцлагагатай үйл ажиллагаа юм.

# 3.

## ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

1

**Татварын ерөнхий хууль**  
(2019 он)

2

**Татвар төлөгчийн  
бүртгэлийн журам**

*(Татварын ерөнхий газрын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/268, А/1345 дугаар хамтарсан тушаал)*

3

**Монгол Улсад байнга оршин суугч болон оршин суугч бус албан татвар төлөгчийг тодорхойлох, бүртгэх, бүртгэлээс хасах, албан татварын тооцоо хийх журам**

*(Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/266 дугаар тушаалын хавсралт)*

4

**Төлөөний газрыг бүртгэх, бүртгэлээс хасах, албан татвар төлөх, тайлагнах журам**

*(Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/272 дугаар тушаалын хавсралт)*

# 4.

## ТАТВАР ТӨЛӨГЧ-ХУВЬ ХҮНИЙ БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ

Хувь хүний татвар ногдуулалт төлөлтөд хяналт тавих зорилгоор татварын алба нь татвар төлөгчдийг дараах ангиллаар ангилж бүртгэнэ:

- Орлогын татвар төлөгчийн хувьд:

Байнга оршин суугч татвар төлөгч

Оршин суугч бус татвар төлөгч

Бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэгч

Хялбаршуулсан горимоор татвар төлөгч хувь хүн

- Татварын төрлөөр:

ХХОАТ төлөгч

НӨАТ төлөгч

Нийслэл хотын албан татвар төлөгч

Хөрөнгийн татвар төлөгч

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөгч
- Галт зэвсгийн албан татвар төлөгч
- Малын тоо толгойн албан татвар төлөгч

Төлбөр, хураамж төлөгч

- Газрын төлбөр төлөгч
- Ус бохирдуулсны төлбөр төлөгч
- Агаарын бохирдлын төлбөр төлөгч
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөгч
- Усны нөөц ашигласны төлбөр төлөгч
- Рашаан ашигласны төлбөр төлөгч
- Ойн нөөц ашигласны төлбөр төлөгч
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр төлөгч
- Байгалийн ургамал ашигласны төлбөр төлөгч
- Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж төлөгч

- Татварын харьяаллаар:

Оршин суугаа аймаг/сумаар

Оршин суугаа нийслэл/дүүргээр

Том, дунд, жижиг, бичил, хувь хүн-татвар төлөгч

# 5.

## ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ДУГААР, ХУВИЙН ХЭРЭГ

- Татварын алба бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээлэл, эсхүл татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэж, татвар төлөгчийн дугаар, татвар төлөгчийн гэрчилгээ олгож, хувийн хэргийг үүсгэнэ.
- “Татвар төлөгчийн гэрчилгээ” гэж татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас татвар төлөгчид олгосон, татвар төлөгчийн дугаартай, татварын төрлийн мэдээллийг тусгасан тусгай нууцлалын кодоор баталгаажсан, цахим болон цаасан баримт бичгийг;
- “Татвар төлөгчийн дугаар” гэж татварын албанаас татвар төлөгчид олгосон татвар төлөгчийн бүртгэлийн нэгдсэн системийн дахин давтагдашгүй дугаарыг;
- Татвар ногдох зүйлийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, эсхүл татвар ногдох зүйл бүхий этгээд, татвар төлөгчид олгосон болон өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн зөвшөөрлийн мэдээллийг бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээлэл, эсхүл татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн татварын алба тухай бүр татварын төрлийн бүртгэл үүсгэж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.
- Татвар төлөгчийн дугаарыг нэг удаа олгох бөгөөд гадаадын иргэний хувьд татварын албанаас олгосон 11 оронтой дахин давтагдашгүй дугаар, иргэний хувьд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан Монгол Улсын иргэнд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас өгөгдсөн 12 орон бүхий тоог байна.
- Иргэний бүртгэлийн дугаар буюу татвар төлөгчийн бүртгэлийн дугаарыг Монгол Улсын иргэний үнэмлэх болон түүний QR кодоор дамжуулан харах, мөн Цахим баримтын систем /и-баримт/ аппликэйшн, e-mongolia онлайн системээс харах боломжтой.
- Татвар төлөгчийн хувийн хэрэг нь татвар төлөгчийн бүртгэл, тайлан, татвар төлөлт, буцаан олголт, суутган тооцоолол, хяналт шалгалт, эрсдэлийн тооцоолол, татварын албанд гаргасан санал, хүсэлт, гомдол, хөнгөлөлт, чөлөөлөлтийн материал, татвар төлөгчийн талаарх бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн тодорхойлолт, лавлагаа, мэдээлэл зэрэг татварын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгээс бүрдэнэ.



## 6.

## ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ЭРХ

	Татвар төлөгчийн эрх	Татварын Ерөнхий хуулийн заалт
1	Татварын албанаас мэдээлэл, заавар, зөвлөлгөө авах	12.1.1. татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөгчийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхтэй холбогдсон мэдээлэл, зөвлөгөө, чиглэл, татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам, аргачлал, маягтыг татварын алба, татварын улсын байцаагчаас авах;
2	Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх	12.1.2. татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх;
3	Төлөх татварын хугацааг сунгуулах	12.1.3. хууль тогтоомжийн дагуу татвар төлөх хугацааг сунгуулах;
4	Илүү төлсөн татвараа буцаан авах, алданги нэхэмжлэх	12.1.4. илүү төлсөн татварыг буцаан авах, суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах;
5	Татварын мэргэшсэн зөвлөх, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх	12.1.5. эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, төлөөлүүлэх, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах;
6	Татварын албаны шийдвэртэй танилцах, тэдгээрт гомдол гаргах	12.1.6. татварын албанаас гаргасан татварын акт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор захиргааны болон шүүхийн журмаар гомдол гаргах;
7	Татварын улсын байцаагчаас тайлбар авах, тайлбар өгөх	12.1.7. татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;

	Татвар төлөгчийн эрх	Татварын Ерөнхий хуулийн заалт
8	Татварын алба, татварын улсын байцаагчид шаардлага тавих, хохирлоо нэхэмжлэх	12.1.8. татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг татварын алба, татварын улсын байцаагчаас шаардах, татварын албаны хууль бус шийдвэр, үйлдлийн үлмаас учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;
9	Татварын албаны шийдвэрт захиргааны болон шүүхийн журмаар гомдол гаргах	12.1.9. татварын алба, татварын улсын байцаагчийн хууль бус ажиллагаа болон шийдвэрт холбогдох гомдлыг түүнийг шууд захирдаг болон дээд шатны албан тушаалтанд, түүнчлэн шүүхэд гаргах. Ийнхүү гомдол гаргасан нь ногдуулсан татвар, торгууль, алдангийг төлөхийг зогсоох үндэслэл болохгүй;
10	Татварын зөвлөхийн туслалцаа авах	12.1.10. татварын хууль тогтоомжоор ногдсон үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн итгэмжлэгдсэн нягтлан бодогч, татварын зөвлөхийн туслалцаа, зөвлөгөө авах;
11	Хууль тогтоомжид зааснаас илүү татвар төлөхгүй байх	12.1.11. хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулсан татварыг тогтворжуулсан хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх;
12	Бусад	12.1.12. хууль тогтоомжид заасан бусад эрх.

# 7.

## ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ

	Татвар төлөгчийн үүрэг	Татварын ерөнхий хуульд заасан үүрэг (хуулийн заалт)
1	Татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх	28.10. Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.
2	Татвар төлөгчөөр бүртгүүлэх	25.1. Татварын хуулиар татвар төлөх, эсхүл татвар суутгах үүрэг бүхий этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлнэ.
3	Татварын тайлан гаргаж тушаах	29.1. Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. 30.5. Татвар төлөгч энэ хуулийн татварын албаны шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан шаардлагад заасан зөрүүг арилгаж, залруулсан тайланг тушаах үүрэгтэй.
4	Татвараа хугацаанд нь төлөх	28.8. Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө.
5	Татварын албаны мэдэгдлийн дагуу хяналт шалгалтад хамрагдах	41.1. Татвар төлөгч татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг татварын алба хянан шалгана 41.12.1. эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах, нотолгоо, үндэслэл гаргах; 41.12.2. татвар ногдуулалт, төлөлт, татварын хяналт шалгалтын явц, үр дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх; 41.12.3. татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгч, татварын хяналт шалгалтад хамрагдах.
6	Татварын албанд мэдээлэл өгөх	28.4. Татвар төлөгч татвар ногдох эд хөрөнгө, эрхийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн болон шилжүүлж авсан тухай баримтыг шилжүүлсэн тухай бүрд татварын албанд гаргаж өгөх үүрэгтэй. 26.9. Монгол Улсад байнга оршин суугч

		<p>албан татвар төлөгч Монгол Улсын иргэн нь гадаад улсад байгуулсан хуулийн этгээдийн нэр, хаягийг тухайн татварын жилд багтаан татварын албанд мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>38.2.Татвар төлөгч хяналтад байгаа ажил гүйлгээний мэдээллийг хадгалах, тайлагнах үүрэгтэй хүлээнэ.</p>
7	Татварын цахим системд холбогдох, бүртгэгдэх	<p>28.2. Татвар төлөгч ногдуулалт хийхдээ хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.</p> <p>29.7. Цахим хэлбэрээр татварын албанд илгээсэн татварын тайланг цахим гарын үсгээр баталгаажуулсан байх бөгөөд баталгаажуулаагүй тохиолдолд цаасан хэлбэрээр тушаана.</p>
8	Цахим баримт үйлдэх	<p>28.5. Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.</p>
9	Татварын алба, татварын улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх	<p>79.1. Татварын албанаас татвар хураах, хяналт тавих, татварын шалгалт хийхтэй холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гаргасан шийдвэрийг мэдэгдэл, шаардах хуудас, битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас, нөхөн ногдуулалтын акт, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, илтгэх хуудас, тэмдэглэл, татварын буцаан олголтын акт, нэхэмжлэх, урьдчилан нэхэмжлэх хуудас, мэдэгдэх хуудас, шаардлага, сүүтгалын хүсэлт, хуваарилалтын тооцооллын акт, зарлан дуудах хуудас, битүүмжлэх мэдэгдэх хуудас, зөвлөмж болон татварын албаны үйлдэх бусад баримт бичиг үйлдэн баталгаажуулна.</p>
10	Хууль тогтоомжид заасны дагуу татварыг суутган төлж тайлагнах	<p>28.7. Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэгтэй этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.</p> <p>83.1. Суутгавал зохих татвараа суутгаагүй, эсхүл суутган авсан боловч төлж, тайлагнаагүй суутган төлөгч нь уг татварыг нөхөн төлөх үүрэгтэй.</p>

# 8.

## ТАТВАР ТӨЛӨГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Татварын хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид татварын улсын байцаагч хариуцлага хүлээлгэнэ.

### 8.1 ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

	Хууль тогтоомж	Зөрчлийн агуулга	Татварын улсын байцаагчийн хүлээлгэх хариуцлага
1	Татварын ерөнхий хууль: 82-р зүйл	<ul style="list-style-type: none"> <li>Татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах зорилгоор;</li> <li>Татвар ногдох зүйлийг нуух зорилгоор татвар ногдуулаагүй</li> <li>Татварын ногдлыг бууруулсан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Татварыг нөхөн төлүүлж, дараах хэмжээгээр торгоно:               <ul style="list-style-type: none"> <li>82.1.1. төлбөл зохих татварын дүнг 50 хүртэл хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын дүнгийн 30 хувиар;</li> <li>82.1.2. төлбөл зохих татварын дүнг 50 ба түүнээс дээш хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар</li> <li>82.2. Зөрчлийг давтан үйлдвэл, тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.</li> </ul> </li> </ul>
2	Татварын ерөнхий хууль: 83-р зүйл	<ul style="list-style-type: none"> <li>Суутгавал зохих татвараа суутгаагүй, эсхүл суутган авсан боловч төлж, тайлагнаагүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Татварыг нөхөн төлүүлж, дараах хэмжээгээр торгоно:               <ul style="list-style-type: none"> <li>83.2. Нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 40 хувиар торгоно.</li> <li>83.3. Зөрчлийг давтан үйлдвэл, тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.</li> </ul> </li> </ul>

3	Татварын ерөнхий хууль: 84-р зүйл	<ul style="list-style-type: none"> <li>• Төсөвт төлөх Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын хэмжээг бууруулах зорилгоор: <ul style="list-style-type: none"> <li>- НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх шаардлагыг хангасан боловч гэрчилгээ авалгүйгээр бараа, ажил үйлчилгээ (БАҮ) борлуулсан,</li> <li>- НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлсэн этгээд борлуулсан БАҮ-нд НӨАТ ногдуулаагүй;</li> <li>- НӨАТ суутган төлөгч борлуулсан БАҮ-нд НӨАТ ногдуулсан боловч төсөвт төлөөгүй;</li> <li>- НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлээгүй этгээд борлуулсан БАҮ-д НӨАТ ногдуулсан боловч төсөвт төлөөгүй;</li> <li>- НӨАТ-ын падаан, төлбөрийн баримтын мэдээллийг зөрүүтэй гаргасан, эсхүл падаан, төлбөрийн баримтыг үйлдээгүй.</li> </ul> </li> </ul>	<p>84.1. Татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно.</p> <p>84.2. Зөрчлийг давтан үйлдвэл, татварыг нөхөн төлүүлж тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно хувиар торгоно.</p>
4	Татварын ерөнхий хууль: 73-р зүйл	<ul style="list-style-type: none"> <li>• Татвар төлөгч хуулиар тогтоосон хугацаанд татвараа төлөөгүй бол</li> </ul>	<p>73.2.1. татварыг төлбөл зохих өдрөөс түүнийг төлсөн өдрийг хүртэлх хоногийн тоогоор тооцон алданги ногдуулна. Алдангийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн татварын жилийн 1 дүгээр сард багтаан тогтооно.</p> <p>2022 оны хувьд: Хоног тутамд 0.038 хувь</p>

## 8.2 ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ:

	Хуулийн заалт	Зөрчлийн агуулга	Татварын улсын байцаагчийн хүлээлгэх хариуцлага
1	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 1	<ul style="list-style-type: none"> <li>Татварыг хуулиар тогтоосон хугацаанд нь төлөөгүй бол</li> </ul>	<p>1. Хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй татварын 0.1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>-торгүүлийн хэмжээ нь төлөх татварын хэмжээний 10 хувиас хэтрэхгүй байна.</p>
2	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 2	<ul style="list-style-type: none"> <li>Татвар төлөгч нь дараах үүргээ зөрчсөн бол: <ul style="list-style-type: none"> <li>- татвар төлөгчөөр бүртгүүлэх;</li> <li>- татварын албанд хувийн хэрэг нээлгэх;</li> <li>- татварын тайланг хугацаанд нь татварын албанд тушаах;</li> <li>- орлогоос бусад татвар ногдох зүйлийг өмчлөгч, эзэмшигч нь хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд мэдэгдэх,</li> <li>- санхүүгийн тайлан, бүртгэлийг журмын дагуу хөтлөх;</li> <li>- Стандартын шаардлага хангасан кассын машин, хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, төлбөрийн баримтын цаас, пос терминал машин хэрэглэх;</li> <li>- төлбөрийн баримтыг татварын нэгдсэн системийн санд илгээх үүргээ биелүүлээгүй хүнийг</li> </ul> </li> </ul>	<p>2. Хүнийг 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. (1 нэгж 1000 төгрөг)</p>
3	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 3	<ul style="list-style-type: none"> <li>Татвар төлөгч нь дараах үүргээ зөрчсөн бол: <ul style="list-style-type: none"> <li>- үл хөдлөх эд хөрөнгө худалдах, бэлэглэх зэргээр өмчлөх эрхээ бүсдад шилжүүлсэн өдрөөс хойш 7 хоногт багтаан харьяалагдах татварын албанд мэдэгдэх;</li> <li>- хуулийн этгээдийн мэдээлэл, хувийн хэрэгт тусгагдсан зүйл</li> </ul> </li> </ul>	<p>3. Хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>

		<p>өөрчлөгдөх бүрд өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор татварын албанд мэдэгдэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- татварын албанаас олгосон бүртгэлийн дугаарыг тайлан, мэдээ, гаалийн мэдүүлэг, төлбөрийн, эсхүл шаардлагатай бусад баримтад тусгах үүргээ биелүүлээгүй бол</li> </ul>	
4	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 4	<ul style="list-style-type: none"> <li>• Татвар төлөгч нь дараах үүргээ зөрчсөн бол: <ul style="list-style-type: none"> <li>- байнга, эсхүл түр оршин суугаа, аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаягаа буруу тодорхойлсон;</li> <li>- татварын албанаас дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй;</li> <li>- хаана оршин суугаагаа үл мэдэгдэж татвар, алданги, торгууль төлөхөөс зайлсхийсэн;</li> <li>- татварын хяналт шалгалтын зорилгоор шаардсан магадлагаа, баримтын хуулбар, банкны гүйлгээний хуулгыг хугацаанд нь ирүүлээгүй;</li> <li>- татварын өр хураах зорилгоор хөрөнгө битүүмжлэхэд саад учруулсан бол</li> </ul> </li> </ul>	4. Татварыг нөхөн төлүүлж хүнийг 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 4000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 5	<ul style="list-style-type: none"> <li>• Татварын байгууллагын эрх бүхий албан тушаалтны битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг: <ul style="list-style-type: none"> <li>- үрэгдүүлсэн;</li> <li>- дур мэдэн бусдад шилжүүлсэн;</li> <li>- гэмтээсэн;</li> <li>- зөвшөөрөлгүйгээр худалдсан бол</li> </ul> </li> </ul>	5. Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 6	<ul style="list-style-type: none"> <li>• Татвар төлөгч хүн, хуулийн этгээд: <ul style="list-style-type: none"> <li>- шаардлагатай нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын мэдээ, холбогдох баримт бичгийг гаргаж өгөөгүй;</li> <li>- байр, агуулахад нь нэвтрэн орох боломж олгоогүй;</li> <li>- тооллого хийлгээгүй;</li> <li>- ажлын зураг авалт, үзлэг, хөрөнгө барьцаалах, эсхүл битүүмжлэх үйл ажиллагааг хийлгээгүй бол</li> </ul> </li> </ul>	6. Хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн бирж, хуулийн этгээдийг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



7	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 7	<ul style="list-style-type: none"> <li>• Татвар төлөгч хүн, хуулийн этгээд, банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн бирж дараах үүргийг зөрчсөн бол: <ul style="list-style-type: none"> <li>- татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдөөгүй;</li> <li>- татвар төлөгч төлбөрийн хуудсыг татварын албанд буцаах үүргээ биелүүлээгүй;</li> <li>- татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй;</li> <li>- татвартай холбогдсон баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, хадгалах талаарх хуулиар тогтоосон журам зөрчсөн бол</li> </ul> </li> </ul>	7. Хүнийг 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн бирж, хуулийн этгээдийг 4000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 8	<ul style="list-style-type: none"> <li>• Бараа, ажил, үйлчилгээ борлуулж байгаа хүн, хуулийн этгээд дараах үүргээ зөрчсөн бол: <ul style="list-style-type: none"> <li>- төлбөрийн баримт олгоогүй бол</li> <li>- төлбөрийн баримтыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон бол</li> <li>- өмнөх тайлант сарын хугацаанд олсон орлогыг тодорхойлох боломжгүй бол төлбөрийн баримт олгоогүй, эсхүл төлбөрийн баримтыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон бол</li> </ul> </li> </ul>	<p>8. Өмнөх тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх дүнгээр торгоно;</p> <p>8. Өмнөх тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>8. Хүнийг 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 15000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
9	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 9	<ul style="list-style-type: none"> <li>• Татварын нэгдсэн сангийн мэдээллийг хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан</li> </ul>	9. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 15000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
10	Зөрчлийн тухай хуулийн 11.19-р зүйлийн 10	<ul style="list-style-type: none"> <li>• Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол</li> </ul>	10. Төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, хүнийг нөхөн төлүүлэх татварын 10 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 11	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээтэй холбоотой үнэ шилжилтийн тайланг хугацаанд нь гаргаагүй бол:</li> <li>• улс бүрээр тайлангийн хувьд</li> <li>• ерөнхий үнэ шилжилтийн тайлан, эсхүл дотоод үнэ шилжилтийн тайлангийн хувьд</li> <li>• үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайлангийн хувьд</li> </ul>	<p>11. Татварыг нөхөн төлүүлж:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 4 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</li> <li>• Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 3 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</li> <li>• Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</li> </ul>
12	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 12	Татварын тайланг гаргасан, эсхүл тайлан гаргахад оролцож гарын үсэг зурсан этгээд, үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн үлмаас зөрчил үйлдэгдсэн бол	12. Хүнийг 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
13	Зөрчлийн тухай хууль: 11.19-р зүйлийн 13	Татварын албанаас шаардсан мэдээллийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй, худал мэдүүлэг өгсөн, мэдээллийг устгасан, өөрчилсөн бол	13. Хүнийг 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 4000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

# 9.

## ЦАХИМ ТАТВАРЫН СИСТЕМД ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР (ХУВЬ ХҮН) БҮРТГҮҮЛЭХ

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Цахим татварын систем дэх татвар төлөгчийн бүртгэл нь татвар төлөх, эсхүл суутгах үүрэг бүхий этгээдийг татвар төлөгчөөр бүртгэх, татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон мэдээллийг бүртгэх, боловсруулах, хадгалах цогц систем юм.

Монгол улсад болон Монгол улсаас эх үүсвэртэй орлого болж байгаа, татвар суутгах үүрэг бүхий хувь хүн, эсхүл татвар ногдох хөрөнгө өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа хувь хүн татвар төлөгчөөр бүртгүүлэх үүрэгтэй.



Татвар төлөгчөөр бүртгүүлэх үйл ажиллагаа цахим хэлбэрээр явагдана.

[www.etax.mta.mn](http://www.etax.mta.mn)

[www.itax.mn](http://www.itax.mn)

**АЛХАМ-1:** Хувь хүн [www.etax.mta.mn](http://www.etax.mta.mn) холбоосоор Нэвтрэлтийн нэгдсэн системд нэвтэрч татвар төлөгчийн бүртгэлээ шалгана. Үүнд:


1. Нэвтрэлтийн нэгдсэн систем цонхны доод хэсэгт байрлах **Татвар төлөгчийн бүртгэл шалгах** товч дарж, гарч ирсэн талбарт иргэний бүртгэлийн дугаар эсхүл регистрийн дугаарыг бөглөж **ШАЛГАХ** товч дарна. Иргэний регистрийн дугаар бөглөхдөө эхний 2 үсгийг том кирилл бичвэрээр бичнэ.



2. Хэрэв татвар төлөгчөөр бүртгэгдсэн бол тус цонхон дээр **Та татвар төлөгчөөр бүртгэлтэй байна** гэсэн мэдээлэл гарна.

3. Хэрэв татвар төлөгчөөр бүртгэгдээгүй бол **Та татвар төлөгчөөр бүртгэгдээгүй байна. Энд дарж бүртгүүлнэ үү** гэсэн мэдээлэл гарна.

**АЛХАМ-2:** Хувь хүн татвар төлөгчийн бүртгэл үүсгэхийн тулд **ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР БҮРТГҮҮЛЭХ** цонхыг дарж **ХУВЬ ХҮН** гэсэн сонголтыг хийнэ.



**АЛХАМ-3: ХУВЬ ХҮН** сонголт хийснээр **ХУВЬ ХҮН ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ** цонх нээгдэнэ. Доорх хүсэлтийг бөглөж **ХҮСЭЛТ ИЛГЭЭХ** товч дарснаар хувь хүн татвар төлөгчөөр бүртгэгдэнэ. Татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай бүртгэгдсэн гар утас, цахим хаягаар мессеж ирнэ. Мессежээр татварын цахим системд нэвтрэх нэр, нууц үг илгээгдэнэ.

1. Улсын бүртгэл, иргэний үнэмлэхэд тэмдэглэгдсэн оршин суугаа хаяг
2. Хувь хүний оршин суугаа хаяг
3. Хувь хүний регистрийн дугаар
4. Хувь хүний ургийн овог
5. Хувь хүний эцэг, эхийн нэр
6. Бүртгүүлэх хувь хүн/татвар төлөгчийн нэр
7. Бүртгүүлсэн утасны дугаарт нууц үг илгээгдэнэ.
8. Бүртгүүлсэн цахим шуудангийн хаягт дугаарт нууц үг илгээгдэнэ.
9. Татвар төлөгчийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл
10. Иргэний үнэмлэхний хуулбар (.pdf өргөтгөлтэй байх)


**АЛХАМ-4:** Татвар төлөгчөөр бүртгүүлсэн хугацаанаас хамаарч НЭВТРЭЛТИЙН НЭГДСЭН СИСТЕМ-д давхар бүртгэгдээгүй байж болно. Энэ тохиолдолд НЭВТРЭЛТИЙН НЭГДСЭН СИСТЕМ –д /etax.mta.mn/ хаягаар нэвтрэн орж **Бүртгүүлэх** товчийг дарж **Хэрэглэгч бүртгүүлэх** цонхонд шилжинэ. Тус талбарыг бөглөснөөр НЭВТРЭЛТИЙН НЭГДСЭН СИСТЕМ-д бүртгэгдэж цахим шуудан, гар утсаар системд нэвтрэх нэр, нууц үг хүлээн авч бүртгэгдэнэ.

**1.** Хувь хүний регистрийн дугаар  
**2.** Хувь хүний овог  
**3.** Бүртгүүлэх хувь хүний /татвар төлөгчийн/ нэр  
**4.** Цахим шуудангийн хаяг-Бүртгүүлсэн цахим шууданд нууц үг илгээгдэнэ.  
**5.** Гар утасны дугаар-Бүртгүүлсэн дугаарт нууц үг илгээгдэнэ

**АЛХАМ-5:** Монгол Улсын иргэн та өөрийн иргэний бүртгэлийн дугаар (12 оронтой тоо бүхий татвар төлөгчийн дугаар)-ыг нэвтрэх нэр болгон ашиглаж ЦАХИМ ТАТВАРЫН СИСТЕМ болон ЦАХИМ БАРИМТЫН СИСТЕМ-д татварын албанаас ирүүлсэн нууц үгийг оруулж нэвтрэн орно. Үүнд:

**Иргэн та хувийн мэдээллээ хамгаалах үүднээс Нэвтрэлтийн Нэгдсэн Системд хандалт хийхдээ Иргэний бүртгэлийн дугаараа ашиглан нэвтрэх боломжтой.**

Иргэний бүртгэлийн дугаараа Ибаримт аппликейшн рүү нэвтрэн харно уу



Татвар төлөгчийн дугаар: 123456789012

**ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛЬ**


ЦАХИМ ТАТВАРЫН СИСТЕМ, ЦАХИМ БАРИМТЫН СИСТЕМ-д татвар төлөгч **иргэн** 12 оронтой тоо бүхий ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ДУГААР буюу **ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ДУГААР**-ыг ашиглаж эхлэлээ.


**ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ДУГААР**-ыг Монгол Улсын иргэний үнэмлэхний QR кодыг уншуулан, e-tax.mta.mn хаягаар нэвтрэн, ebarimt аппликэйшнд нэвтрэн харах боломжтой.


Татвар төлөгч та цахим баримтаа авахдаа өөрийн РЕГИСТРИЙН ДУГААР биш **ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ДУГААР**-аа өгч хувь хүний мэдээллийн нүүцаа хамгаална уу.

**АЛХАМ-6:** ЦАХИМ ТАТВАРЫН СИСТЕМ-д нэвтрэн орсноор хувь хүнийг бүртгэсэн мэдээлэл харагдана.


Хэрэглэгчийг сонгож системд бүрэн нэвтэрснээр бүх төрлийн татварын тайланг цахимаар илгээх, татварын албанд хүсэлт гаргах, тайланд засвар өөрчлөлт оруулах, тайлангийн түүхээ харах, татварын ногдол, нэхэмжлэл болон татвар төлөлтөө хянах, тодорхойлолт авах, цахим төлбөрийн баримт үүсгэх зэрэг татвартай холбоотой бүхий л үйлчилгээг цахимаар авах боломжтой болно.



**АЛХАМ-7:** Цахим татварын системээс Цахим баримтын системд дамжин орохдоо ДЭЛГЭЦ-ын БАРУУН ДЭЭД ӨНЦӨГТ байрлах  сонголтоор орно.



**АЛХАМ-8:** Цахим татварын системээс татвар төлөгчийн гэрчилгээ авах, үйлчилгээ авах өөрийн мэдээллийг шалгаж, засах боломжтой.



**АЛХАМ-9.** Татварын албаар үйлчлүүлсэн танд баярлалаа.

